

У. ОЮУТНЫ БҮТЭЭЛЭЭС

ОЛОН УЛСЫН ХАРИУЦААНЫ ОНОЛЫН СҮРГУУЛИУДЫГ СУДААХ АЧ ХОЛВОГДОЛ

МУИС, ОУХС-ийн 4-р ангиин
оюутан А.Амарсанаа

Энэ илтгэлд ОУХ-ны онолын сургуулиудыг Монголд судлах хэрэгтэй юу гэсэн асуултанд харуулахыг хичээсэн.

Нийгмийн ээдрээтэй, ярвитагй, олон талт асуудлуудыг гүйцэд ойлгохын тулд онолын мэдлэг зайлшгүй хэрэгтэй болдог. Тухайн нэг улсын гадаад бодлогын шийдвэр гаргагч институтци, хувь хүний нэг улсын гадаад бодлого болдог ямар түвшин, хэлбэртэй байхаас ОУХ-гарт онолын суурь мэдлэг ямар түвшин, хэлбэртэй байхаас ОУХ-ны үйл явдал шууд хамааралтай болно. Олон улсын үйл явдлыг судлах, задлан шинжлэх, тайлбарлах зэрэг нь ОУХ-ны онолын ямар сургууль баримталдаг вэ гэдгээс шалтгаалан тодорхой үр дүн гарна.

ОУХ-ны онол, практик, бодлого гурав хоорондоо салшгүй холбоотой билээ. Онол нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт удирдлага болдог. Бодлого хэрэгжсэнээр онолчдын хувьд судлах зүйлийг шинээр бүрэлдүүлэхийн зэрэгцээ онолыг улам боловсронгуй болгох хүчин болдог (Lopez & Stohl 1989, p. 5). Үүнд ОУХ-ны онолын судлалын практик ач холбогдол оршдог.

ОУХ-ны онол гэдэг бол иж бүрэн харилцан холбоотой хоорондоо маргаж мэтгэлцэж байдаг олон сургуулиудын үзэл санааны нийлбэр бөгөөд өөрөө өөрийгөө засан залруулж чадах цогц мэдлэг юм. Энэ цогц мэдлэг нь ОУХ-ны юм, үзэгдлийн зүй тогтлыг системчлэх чиглэлтэй бөгөөд ОУХ-ны өнгөрсөн, одоо ирээдүйг ойлгох, таамаглахад ач холбогдолтой юм.

Олон янзын тодорхойлолтуудыг харьцуулахад мэдлэг гэсэн үг давхарддаг. Хэрвээ онол нь "цогц мэдлэг" юм бол онолын сургуулиуд нь түүнийг бүрэлдүүлж буй мэдлэгийн хэсгүүд болно. Тэгэхлээр, ОУХ-г бүрэн дүүрэн ойлгох нь онолын цогц мэдлэгийг олж, онолын сургуулиудыг тус бүрт нь задлан шинжлэх хэлбэрээр хэрэгжинэ.

А.Амарсанаа

"Олон улсын харилцааны онолын сургуулиудыг судлах ач холбогдол"

Онолын сургуулиудыг олон төрөл, ангилалд хуваан үздэг ба энэ нь байнга өөрчлөгдөж байдаг. Асуудлыг ямар өнцөгөөс үзэж шийдэхээс шалтгаалан ангилал янз бүр байж болно. Голдуу ОУХ-ны онолын сургуулиудыг ерөнхий (реалист, идеалист, биеворалист, марксист), газарзүй, гарал үүсэл, түүхэн үечлэл, хэв шинж, үүргээр ангилж болгох юм. Гэсэн хэдий ч, уламжлалт онолын сургуулиуд, тэдний орчин үеийн хувилбарууд (реализм ба идеализм, неореализм ба неолиберализм); орчин үеийн уламжлалт бус урсгал (биеворалист, пост-позитивист урсгал, конструктивизм г.м.); дорнын онолын урсгалууд (Ялалын онол, Япон, Хятадын онцлогтой онол г. м.) гэж гурван ерөнхий бүлэгт хуваан үзэн судалбал их хялбар болно. Энэ ангилал нь хэд хэдэн зүйлээр бусад ангиллуудаас давуу талтай. Нэг талаар, газарзүйн байршил, соёл иргэншлийн үүднээс нөгөө талаар, түүхийн явцад давамгайлах (эхний хоёр бүлэгт хамаарна), ОУХ-ны онолын судлалд эзлэх жин нөлөө буурах дарааллаар ангилсан юм. Өөрөөр хэлбэл, ОУХ-ны судлал, практик неореализм, неолиберализм хамгийн их эзлэх жинтэй, дараа нь, пост-позитивист урсгал, конструктивизм, хамгийн сүүлд дэлхий даяар түгээмэл бус, бүс нутгийн шинжтэй онолын сургуулиуд гэх зэрэг. "Бүс нутгийн" бүлгийн ангилалд тухайн улс орон өөрийн онцлог сэтгэлгээг гарган ирэх оролдогууд багтаж байгаа юм.

Нэг мөр, үнэн зөв, гүйцэд тайлбар, хариулт өгсөн практик онол гэж өр үгүй. Тийм онол хэзээ ч төрөхгүй болов уу. Онолын сургуулиуд хэдий сайн боловсрогдсон байлаа ч цаг үеийн шинэчлэлт өөрчлөлт, нийгмийн хөгжлийг даган илүү гүнзгий боловсрогдсоор байдаг. Зарим нэг нь бүр хувьсан өөрчлөгддөг. Хариулж чадахгүй байгаа асуултын хариултыг олох "мөнхийн эрэл, хайгуул" зогсолтгүй явагдана. Ер нь, өөрчлөлт шинэчлэлт ОУХ-ны тухай ухааны мөн чанар болж өгдөг.

Манай улсын ОУХ, олон улс судлалын эрдэмтэн судлагчид дэлхийн нийтийн ОУХ-ны шинжлэх ухаанд өөрийн гэсэн хувь нэмэр оруулах, эргээд эх орондоо түүнийг судлах, хөгжүүлэх шаардлага байдгийг хүлээн зөвшөөрдөг. Үүнд мэдээж хэрэг, ОУХ-ны онолын судалгаа ихээхэн үүрэгтэй. Үнэхээр, Монголын судлагчид энэ сэдвийг судлах талаар, ялангуяа өнөөдөр, гар хумхин сууж хэрхэвч болохгүй. "Далайд дуулал нэмэр, давсанд шүү нэмэр" гэдэг энэ буюу.

А.Амарсанаа

"Олон улсын харилцааны онолын сургуулиудыг судлах ач холбогдол"

ОУХ-ны онолын сургуулийн аль нэгийг зөв, буруу хэмээн дүгнэж "үүнийг үзнэ, түүнийг үзэхгүй" гэж хэрхэвч болохгүй. Онолын гол сургуулиудын үзэл санааг сайтар мэдсэний эцэст л өөрийн онолын мэдлэг бүрэлдэн буй болно. Ингэж судалгаа хийхэд түүхэн талаас, иш үндэстэй нь судлах хэрэгтэй.

Монголд ОУХ-ны онол, сургуулиудын талаар судалгаа хомс байгаагийн шалтгаан нь, миний бодлоор, манайд уг сэдвийн талаар орчуулсан судалгааны эх сурвалж байтугай, олон улсын нэр нөлөө бүхий эрдэмтэн судлагчдын жинхэнэ эх материал ч ховор байгаатай холбоотой байж болох юм.

Уг сэдвийн талаарх дэлхийн түвшин дэх судлагдсан байдлыг тоймлон авч үзэхэд АНУ энэ салбарт тэргүүлж байна. Дэлхийн 2-р дайнаас хойш энэ улс ганцаараа ОУХ-ны онолын судлагдахууны гол нурууг авч ирсэн. ОУХ-ны шинжлэх ухаан, түүний онолын тухай гол гол мэргэжлийн сэтгүүлүүд энэ улсад л гарч байна. Тухайлбал, International Security, International Organization, World Politics, Foreign Policy, Foreign Affairs зэрэг дэлхийд нэр нөлөө бүхий Америк сэтгүүлдүүдийг дурьдаж болох юм. Энэ улс олон улсын харилцааны их, дээд сургууль, коллежи болоод судлагч, эрдэмтэдийн тоогоор бусад ямар ч орныг ардаа хол орхижээ. Түүгээр үл барам, АНУ-ын Олон Улс Судлалын Холбооны (US International Studies Association) бага хурал жил бүр хуралдаж нэр нөлөө бүхий эрдэмтэн судлагчид ОУХ-ны онолын асуудлуудыг тусад нь нарийн авч үздэг байх юм. ОУХ-ны ухаанд АНУ, Англи ба бусад өрнөдийн орнуудын эрдэмтэн судлагчдын судалгаа дэлхийд давамгайлж ирсэн нь ойрын ирээдүйд өөрчлөгдөхгүй болов уу.

Ер нь Монгол гэлтгүй бүх улс орны хувьд ОУХ-ны байдлыг онолын суурь мэдлэгтэй ойлгож байх нь зайлшгүй зүйл юм. Онол бидэнд ОУХ-г ямар арга замаар ойлгох, бидний дэлхийн "нийгэмд" эзлэх байр суурийг тодорхойлох зэрэг асуудлуудыг шийдэж өгөх учиртай юм.

ОУХ-ны онолыг судлахдаа сайн онол, муу онол гэж ярих нь утгагүй. Харин хэрэглэж болох онол, хэрэглэж болохгүй онол гэдэг дээр их анхаарах хэрэгтэй. Хэрэглэж болохгүй онолыг хэт хоцрогдсон, тухайн цаг үетэйгээ зохицохгүй болсон гэдэг утгаар ойлгоно.

ОУХ-ны онол сургуулиуд голдуу цаг үе, орчин байдлаа даган

өөрчлөгдөн цаг үеийн шууд тусгал болсоор ирсэн. Иймд, онолд тодорхой хугацаанд шинэчлэгдэн, өөрийгөө засан "залруулах механизм" байдаг. Өөрөөр хэлбэл, "уян хатан" байх зарчим үйлчилнэ. Нийгмийн нарийн асуудлыг тусгахгүй хэт хялбаршихаас сэргийлсэн үзэл дээрх механизмыг хөдөлгөж өгдөг.

ОУХ-ны онол, сургуулиудын хөгжлийн орчин үеийн ерөнхий тоймыг дүгнэж үзвэл дараах байдалтай байна. Үнд.

1. Өрнийн буюу Америкийн эрдэмтэдийн судалгаа дэлхий нийтийн ОУХ-ны онолын судлал болж хүлээн зөвшөөрөгдсөн;

2. Орчин үед дэлхий нийтийн онолын судлал доорх гурван чиглэлээр хөгжиж байна. Үнд: неолиберал ба неореалист онолын сургуулиудын "мэтгэлцээн"; пост-позитивист ба конструктивист урсгал, сургуулиуд; нийгмийн янз бүрийн бүлэг, давхаргын (эмэгтэйчүүд, үндэстний цөөнх, хүүхэд, г. м.) эзлэх байр суурь, жин нөлөөг анхааран судлахад чиглэсэн феминист сургууль;

3. Янз бүрийн соёл иргэншил, хэл, соёлтой эрдэмтэн судлагчид ОУХ-ны онолын судлалд идэвхтэй хамрагдах болсон (ялангуяа, Ази, Лалын орнуудад)

Эдүгээ онолын үзэл баримтлалаа хэт баригдсан, хатуу байр суурьтай байх нь хоцрогдож орчин үетэйгээ хөл нийлүүлсэн уян хатан, дасан зохицох хандлага түгээмэл байна. ОУХ-ны хөгжлийн цаашдын төлөв нь өргөн хүрээний асуудлыг хамарсан "нэгдмэл, цогцолбор, уян хатан" онол (complexity theory) хөгжих ирээдүйтэй. Үнд пост-позитив болон конструктив урсгалууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, ОУХ-ны судалгаа шинжилгээний онол арга зүйг сайтар эзэмшсэн, ОУХ-ны чиглэлээр нарийн мөргөшсөн, гадаад хэлний өндөр мэдлэгтэй боловсон хүчнийг системтэй сургаж бэлтгэх ажил ОУХС-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл билээ. Нэгэнт ийм чиглэл байхад ОУХ-ны онолын сургуулиудын судалгаа, шинжилгээ ус агаар шиг хэрэгтэй билээ.

Иймд ОУХ-ны онолын судалгааг Монголд өрнүүлэх, эрдэмтэдийн анхаарлыг татах хэдэн санал байна. Үнд:

- ОУХС-ийн сургалтын хөтөлбөрт ОУХ-ны онолын сургуулиудын тухай бие даасан хичээлийг оруулах;
- Бидний ОУХ-ны онолын сургуулийн тухай ойлголт цаг үетэйгээ таарч тохирохгүй хоцрогдоод байгаа учир орчин үеийн урсгал,

- чиглэл болох пост-позитивизм, консррактивизмын талаар судалгааг эхлүүлэх;
- ОУХ-ны шинжлэх ухааны судалгаа англи хэл дээр голчлон байх учир монгол хэл рүү нэр томъёонуудыг хөрвүүлэн нэг мөр болгох зайлшгүй шаардлага байна.
- Дээрх саналууд бол Монгол нөхцөл, сууринд тулгуурласан, монголчлох сэтгэхүйгээр ОУХ-г судлах гэж байгаа бус харин "нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн" онолын сургуулиуд Монгол улсад хэрхэн нөлөөлөх гэдэгт чиглэж байгаа юм. Нөгөө талаар, ОУХ-ны онолын судалгааны ажиг монголын судлагчдад өргөн цар хүрээтэй, дэлхийн түвшинд судалгаа явуулах суваг нээж байгаа юм.

НОМЗҮЙ:

1. Booth, K. & Smith, S. (eds) 1995 : *International Relations Theory, The Pennsylvania State University Press*, 1995
2. Kegley Jr., C. W. & Wittkopf, E. R. 1993: *World Politics, Trend and Transformation*, 4th ed., NY: St. Martin's Press.
3. Viotti, P. R. & Kauppi, M. V. - 2nd ed., 1993: *International Relations Theory: Realism, Pluralism, Globalism*, NY: Macmillan Publishing Company
4. Cox, Robert W. & Timothy J. Sinclair 1996: *Approaches to World Order*, Cambridge, p.82.
5. Lopez, G. A. & Stohl, M.S. 1989: *International Relations: Contemporary Theory and Practice*, Congressional Quarterly.
6. Төмөрчулуун, Г. 1995 (а) "Прагматизм: 90-ээд оны Монголын гадаад бодлогын үндэс" (Батбаяр, Ц. (ред.), 1995: 1990-ээд оны Олон Улсын Харилцааны Хандлагууд: Монгол Улс – Их гурнуудийн харилцаа, УБ.
7. Бор, Ж. 2000: Олон Улсын Бодлогогүйн Онолын Асуудалд. Алтан Арсаж, 1, (3) 3-8.
8. Төмөрчулуун, Г. 1995 (б). ОУХ-ны Онолын Сургуулиуд. Шинэ Толь. 1/1995. 59-63.

ДЭН СЯОПИНЫ ҮЕИЙН БНХАУ-ЫН ГАДААД БОДЛОГО

МУИС, ОУХС-ийн 3-р ангийн
оюутан Я.Болд-Эрдэнэ

БНХАУ-н II үеийн удирдагч гэж алдаршсан Дэн Сяопин (1904-1997) нь Хятадын удирдагчдаас хамгийн өндөр насалсан, хамгийн олон албан тушаалыг хавсран гүйцэтгэж байсан хүн юм. Тэрээр 1980-д оныг хүртэл нэг бус удаа ерөнхий сайдын орлогчийн албыг хашиж байсан, Орос, Францад боловсрол эзэмшсэн. Хэнтэй ч юуны ч талаар сонирхолтой яриа өрнүүлчихдэг, гадныхны өмнө биеэ авч явах өндөр соёлтой нэгэн байжээ. Тэр өөрийгөө тахин шүтүүлээгүйгээрээ онцлогтой.

Мао Эздүны дараа Хятадын төрийн эрхийг Хуа Гофэн хэдэн жил барьсан билээ. Хуа Гофэний үед БНХАУ-н гадаад бодлого Хятадын өнөөгийн гадаад бодлогын дүр төрхийг олж эхэллээ. Гэхдээ түүнд гол гавьяатан нь 1977 оноос засгийн эрхэнд дахин гарч ирсэн Дэн Сяопин байсан юм.

1978 онд ЖКН-н 11 дэх удаагийн 3 дахь бүгд хуралдаанаар Дэн Хятадын онцлогтой социализм байгуулах "Нээлттэй хаалганы бодлого", "4 шинэчлэлийн бодлого" дэвшүүлсэн ба дотоод гадаадын нөхцөл байдлаас хамаарч гадаад бодлогод ч зарим нэг өөрчлөлт гарсан.

Дэн "Социалист Хятад нь 3 дахь ертөнцөд хамаарах ба тэдний талд байх болно" хэмээн цохон тэмдэглээд Хятадын гадаад бодлогын үндэс нь хөгжиж буй орнуудтай хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх Ази, Африк, Латин америкийн орнуудтай харилцан ашигтай, найрсаг, хамтын ажиллагааг баталгаажуулахад оршино" гэж үзэж байжээ. Тэрээр улс хоорондын харилцааг голлосон нийгмийн байгуулал, үзэл суртлын хооронд ямар нэг тэмцэл байх учиргүй хэмээн "ЗХУ, АНУ-тай харилцах чиг шугамаа өөрчлөн дэлхийн бүх оронтой найрсаг хамтын ажиллагааг өргөтгөхийг зорьжээ.

Ийнхүү 1979 оноос БНХАУ шинэчлэлийн замд орсныг Хятадын түүхэн дэх 3 дахь үсрэлт гэдэг. (Эхний нь 1911 онд Манжийн дарлалыг унагасан, удаах нь 1949 онд БНХАУ-г байгуулсан явдал болно.) "Шинэчлэл, нээлттэй бодлого" нь гадаадын шинэ түнш эрж хайж хамтран ажиллахыг шаардсан. 1980 онд тэнгисийн эргийн дагуу 4